

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагын талаар

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдөр баталсан Хууль тогтоомжийн тухай хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх гэж байгаатай холбогдуулан хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах явцад Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараахь хэрэгцээ, шаардлага тулгараад байна.

1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газраас хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалуудыг баталсан.

Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд эдгээр аргачлал нь хамаарахгүй хууль тогтоомжийн төслийг заасан. Гэвч хуулиар зохицуулаагүй харилцааг Засгийн газрын тогтоолоор баталсан аргачлалаар зохицуулсан нь хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэхэд хүргэж байна.

Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсвөөс бүрдэнэ.” гэж заасан бөгөөд жил бүр Улсын Их Хурлаас Монгол Улсын нэгдсэн төсвийг хэлэлцэж, хуульчлан баталдаг. Иймд тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөл боловсруулахад Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх, Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалууд хамаарахгүй бөгөөд тухайн жилийн төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэхтэй холбогдсон харилцааг Төсвийн тухай хуулиар зохицуулах нь зүйтэй.

Түүнчлэн тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Засгийн газраас боловсруулж, Улсын Их Хурлаар яаралтай хэлэлцүүлэхээр өргөн барих хууль тогтоомжийн төсөл, Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөл, “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал батлах тухай”, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”, “Төсвийн гүйцэтгэл батлах тухай”, “Үндсэн чиглэл /хууль тогтоомжийг боловсронгуй болгох, нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, төрөөс мөнгөний талаар тухайн жилд баримтлах/ батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол төсөл зэрэг хууль тогтоомжийн төслийг боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т заасан хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал, 12.1.3-т заасан хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал, 12.1.4-т заасан хууль тогтоомжийг

хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал, 12.1.6-д заасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал нь хамаарахгүй байх зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байна.

Харин Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох болон нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл нь бодлого, төлөвлөлтийн шинжтэй баримт бичиг тул тэдгээрт тусгасан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад холбогдох аргачлалын дагуу үнэлгээ хийх нь зүйтэй юм.

2.Хуульд заасан аргачлалын дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийсэн, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ хийсэнтэй холбогдуулан энэ талаарх материалыг /тайлан, санал дүгнэлт, зөвлөмж/ аль шатанд, хаана баримтжуулж хавсаргаж ирүүлэх талаар хуульд зохицуулаагүй нь дээрх аргачлалын дагуу холбогдох үе шатанд хийсэн судалгаа, үнэлгээ, зардлын тооцоог баримтжуулж хянах боломжгүй нөхцөл байдлыг тодорхой болгох.

3.Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, хууль тогтоомжийн үр дагаврын үнэлгээ хийх асуудлууд нь агуулгын хувьд давхардсанаас хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд учир дутагдалтай байх тул эдгээр зохицуулалтыг нэгтгэж, өөрчлөн найруулах.

4.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр тухайн хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах шаардлагатай талаарх гарсан санал дүгнэлт нь хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг боловсруулах үндэслэл болохоор хуульд тусгах.

5.Хуульд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээг хийх хугацаа тодорхой болгох, эсхүл шаардлагатай үед үнэлгээ хийж байх зохицуулалтыг тусгаж өгөх.

6.Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар бүлэгт захиргааны хэм хэмжээний актын талаарх харилцааг тодорхой зохицуулсан тул Хууль тогтоомжийн тухай хуулиар уг харилцааг давхардуулан зохицуулах шаардлагагүй тул холбогдох зохицуулалтыг өөрчлөх.

7.Хууль тогтоомжийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг хэл зүй, найруулгын тухайд ойлгомжтой, тодорхой болгох шаардлагатай байна.

Иймд дээрх хэрэгцээ, шаардлагын дагуу Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг тодорхойлох талаар.

Хуулийн төсөл нь Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төрөл болно.

Хуулийн төсөлд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана. Үүнд:

1 дүгээр зүйлд хуульд заасан аргачлал хамаарахгүй хууль тогтоомжийн төслийн хүрээг тодорхой тусгасан зохицуулалт болон аргачлалын дагуу судалгаа, үнэлгээ, зардлын тооцоо хийсэн талаарх материалыг холбогдох үе шатанд баримтжуулж ирүүлэх, бүрдүүлбэрт тусгах, хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийг төслийг хуулийн төслийн төрөлд хамааруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх асуудлыг нэгтгэхтэй холбоотой зохицуулалтыг нэмнэ.

2 дугаар зүйлд найруулгын шинжтэй үг, өгүүлбэр нэмэх зохицуулалтыг тусгана.

3 дугаар зүйлд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр хууль тогтоомжийг шинэчлэн найруулах, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай талаарх санал дүгнэлт, зөвлөмж нь үзэл баримтлалыг боловсруулах үндэслэл болохоор, бусад зүйл, хэсэг, заалтыг хэл зүй, найруулгын хувьд өөрчлөн найруулах асуудлыг тусгана.

4, 5 дугаар зүйлд хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хамтран батлах болон хууль тогтоомжийн төсөлд санал авахад “холбогдох төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Засгийн газрын гишүүн” гэж өөрчлөх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх асуудлыг хүчингүй болгож байгаатай холбогдуулан зарим найруулгын шинжтэй үг, өгүүлбэр өөрчлөх асуудлыг тусгана.

6 дугаар зүйлд хүчингүй болгох шаардлагатай зүйл, хэсэг, заалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт ачаалал үүсэхгүй, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэхгүй.

Харин Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байсан асуудлууд арилж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх боломж, нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад холбогдох хуульд тогтоомжуудтай нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хууль байхгүй болно.

----oOo----